



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 4/603

Арвайхээр

Б.Уртнасан, Г.Бямба, Д.Уранбилэг нарт
буцалтгүй тусламж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.3, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газарт үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул Б.Уртнасанд 13,218,595 (арван гурван сая хоёр зуун арван найман мянга таван зуун ерэн тав) төгрөг, мөн байгууллагад үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул Г.Бямбад 14,235,410 (арван дөрвөн сая хоёр зуун гучин таван мянга дөрвөн зуун арав) төгрөг, мөн байгууллагад үйлчлэгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул Д.Уранбилэгт 8,134,520 (найман сая нэг зуун гучин дөрвөн мянга таван зуун хорь) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг тус тус олгосугай.

2.Дээрх буцалтгүй тусламжийн нийт 35,588,525 (гучин таван сая таван зуун наян найман мянга таван зуун хорин тав) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101279